



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур-Ус ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/83/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Эн Ай Ти Эс баланс АудитХХК-ийн захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 99102291 Цахим хаяг: ichinkhorloo2023@gmai.com
Аудитын менежер: И.Туяа
Утас: 99298711 Цахим хаяг: tuyaiishjамts@gmai.com
Ахлах аудитор: С.Алтанхундага
Утас: 99457188. Цахим хаяг: altankhundagas@gmai.com
Аудитор: С.Удвал.
Утас: 99085158 Цахим хаяг: udval1979@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 574

танай _____-ны № _____-т

БАГАНУУР УС
ААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ж.ЭНХБАТ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх явцад ажиглагдсангүй ба материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 12,724.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг холбогдох стандартын дагуу бүртгэж тайлагнаагүйгээс байгууллагын үйл ажиллагааны үр дүн буюу ашигт нөлөөлсөн байна.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын 100 хувь эзэмшилд байдаг 1,816.9 сая төгрөгийн төрийн өмчийг хувийн өмч дансанд бүртгэж тайлагнасан.

Аудитын явцад холбогдох данстад залруулга хийгдсэн тул байгууллагын гэрчилгээнд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Багануур дүүргийн Багануур-Ус ААТҮГ нь тайлант онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 3 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэт	2022 оны 12- сарын 31	2023 оны 12- сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.01	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	439,998,893.84	454,376,234.05
1.1.02	Дансны авлага	359,998,294.44	387,444,937.94
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	12,956,098.79	3,989,957.69
1.1.04	Бусад авлага	21,094,324.34	19,080,022.04
1.1.06	Бараа материал	47,205,874.75	47,778,156.09
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,000,000.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	889,253,486.16	912,669,307.81
1.2.01	Үндсэн хөрөнгө	7,295,171,006.65	7,474,704,207.17
1.2.02	Биет бус хөрөнгө	3,503,452,999.96	3,498,183,999.92
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,798,624,006.61	10,972,888,207.09
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,687,877,492.77	11,885,557,514.90
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.1.1.01	Дансны өглөг	3,433,420.33	869,640.63
2.1.1.03	Татварын өр	0.00	15,816.00
2.1.1.06	Хүүний өглөг	18,826,200.00	18,826,200.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	20,627,765.87	519,024,693.08
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	42,887,386.20	538,736,349.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.01	Урт хугацаат зээл	209,180,000.00	209,180,000.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	209,180,000.00	209,180,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	252,067,386.20	747,916,349.71
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.01	Өмч-Төрийн	1,816,924,400.62	14,021,502,224.49
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,221,069,116.40	1,220,561,468.90
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	12,204,577,823.87	
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-3,806,761,234.32	-4,104,422,528.20
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-180,191,527.34
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-3,806,761,234.32	-3,924,231,000.86
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,435,810,106.57	11,137,641,165.19
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	11,687,877,492.77	11,885,557,514.90

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12- сарын 31	2023 оны 12- сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,276,162,970.96	3,756,986,483.92
2	Борлуулалтын өртөг	3,443,821,635.39	3,877,359,757.32
3	Нийт ашиг(алдагдал)	-167,658,664.43	-120,373,273.40
4	Хүүний орлого	0.00	2,138,756.95
5	Бусад орлого	200,518,605.76	229,823,553.57
6	Орлогын дүн	200,518,605.76	229,823,553.57
7	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	130,026,521.70
8	Ерөнхий ба удирдлагын зардал	144,960,365.09	158,401,410.10
9	Зардлын дүн	144,960,365.09	288,427,931.80
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз	-127,764,776.95	
11	Бусад ашиг (алдагдал)	-6,366,348.89	-1,000,000.00
12	Олз, гарзын дүн	-134,131,125.84	-1,000,000.00
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-246,231,549.60	-179,977,651.63
14	Орлогын татварын зардал	0.00	213,875.71
15	Татварын дараах ашиг (алдагдал)	-246,231,549.60	-180,191,427.34
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-246,231,549.60	-180,191,527.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12- сарын 31	2023 оны 12- сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,726,316,050.05	3,649,076,151.37
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,512,180,005.07	3,493,372,063.73
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,269,439.00	5,888,077.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	210,866,605.98	149,816,010.64
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,250,640,982.63	3,534,853,632.11
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,125,907,253.39	1,360,864,312.16
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	350,648,108.23	427,190,387.61
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	419,792,544.51	321,047,885.41
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23,351,353.11	23,563,684.42
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	112,070,760.00	82,980,300.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	267,878,028.96	321,631,163.91

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,310,530.00	5,294,509.83
1.2.9	Бусад мөнгөн зарлага	947,682,404.43	992,281,388.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	475,675,067.42	114,222,519.26
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	2,138,756.95
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	2,138,756.95
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	51,635,000.00	101,983,936.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	51,635,000.00	101,983,936.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-51,635,000.00	-99,845,179.05
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	424,040,067.42	14,377,340.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,958,826.42	439,998,893.84
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	439,998,893.84	454,376,234.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 01 сарын 01-ээр үлдэгдэл	1,816,924,400.62	1,549,299,087.90	12,066,032,673.87	-3,888,759,656.22	11,543,496,406.17
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				328,229,971.50	328,229,971.50
03	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-246,231,549.60	-246,231,549.60
04	Өмчид гарсан өөрчлөлт			138,545,150.00		
05	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-328,229,971.50			-328,229,971.50
06	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,816,924,400.62	1,221,069,116.40	12,204,577,823.87	-3,806,761,234.32	11,435,810,106.57
07	2023 оны 01 сарын 01-ээр үлдэгдэл	1,816,924,400.62	1,221,069,116.40	12,204,577,823.87	-3,806,761,234.32	11,435,810,106.57
08	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-117,469,766.54	-117,469,766.54

09	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-180,191,527.34	-180,191,527.34
10	Залруулсан үлдэгдэл					0.00
11	Өмчид гарсан өөрчлөлт	12,204,577,823.87		-12,204,577,823.87		
12	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	-507,647.50	0.00	0.00	-507,647.50
13	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	14,021,502,224.49	1,220,561,468.90	0.00	-4,104,422,528.20	11,137,641,165.19

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд		2022 он	2023 он		Зөрүү	Хувь
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
а	мян.М ₃	Цэвэр усны олборлолт	781.53	840.0	802.29	-37.7	95.5
б	мян.М ₃	Борлуулсан ус	573	638.2	562.16	-76.0	88.1
в	мян.М ₃	Татан зайлуулсан бохир шингэн	527.04	582.7	516.69	-66.0	88.7
г	мян.М ₃	Цэвэрлэж ариутгасан бохир ус	572.04	582.7	516.69	-66.0	88.7
д	Гкал	Түгээсэн дулаан	27.0	28	27.88	0.0	100.0
1	Нийт орлого		3,476,681,576.72	3,755,436,500.00	3,986,810,037.49	231,373,537.49	106.2
1.1	Дулаан түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагаа		1,103,329,198.50	1,253,390,000.00	1,408,658,262.60	155,268,262.60	112.4
1.2	Ус хангамжийн үйл ажиллагаа		1,163,271,325.26	1,269,040,500.00	1,270,582,998.19	1,542,498.19	100.1
1.3	Бохир шингэн татан зайлуулж цэвэрлэх үйл ажиллагаа		1,009,562,447.20	1,033,006,000.00	1,077,745,223.13	44,739,223.13	104.3
1.4	Үйл ажиллагааны бусад орлого		200,518,605.76	200,000,000.00	229,823,553.57	29,823,553.57	114.9
2	Нийт зардал		3,722,913,126.32	4,307,934,800.00	4,166,787,689.12	141,147,110.88	96.7
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		579,247,820.73	658,029,800.00	739,542,459.2	81,512,659.2	112.4
2.2	2.2.1	Цалин	1,342,857,538.09	1,697,545,000.00	1,631,727,352.0	-65,817,648.0	96.1
	2.2.2	НДШ	188,048,974.43	237,650,000.00	228,511,100.8	-9,138,899.2	96.2
	2.2.3	Үндсэн ба туслах материалын зардал	61,772,752.22	85,000,000.00	73,126,183.6	-11,873,816.5	86.0
	2.2.4	Шатахуун	87,438,692.02	96,200,000.00	74,871,663.0	-21,328,337.0	77.8
	2.2.5	Сэлбэг хэрэгсэл / тоног төхөөрөмж	59,050,202.09	65,000,000.00	82,810,591.2	17,810,591.2	127.4
	2.2.6	Унаа хоолны зардал	79,008,000.00	85,000,000.00	102,782,000.0	17,782,000.0	120.9

2.2.7	Хөдөлмөр хамгаалал	52,338,958.43	57,600,000.0	55,134,801.2	-2,465,198.9	95.7
2.2.8	ҮХЭлэгдэл	537,188,670.48	530,000,000.0	487,296,299.5	-42,703,700.5	91.9
2.2.9	Тээврийн зардал	-	0.0	0.0	0.0	0.0
2.2.10	Үл хөдлөх хөрөнгийн татвар	3,120,000.00	3,200,000.00	3,120,000.0	-80,000.0	97.5
2.2.11	Газрын төлбөр	8,444,532.00	8,600,000.00	12,650,735.0	4,050,735.0	147.1
2.2.12	Өөрөө явагч хэрэгслийн албан татвар	350,712.00	380000	1,673,573.0	1,293,573.0	440.4
2.2.13	Ашиглалтын зардал	404,712,748.21	571,000,000.00	489,665,931.9	-81,334,068.1	85.8
2.2.14	Бичиг хэрэг шуудан холбоо	20,663,332.17	20,000,000.00	22,725,596.0	2,725,596.0	113.6
2.2.15	Албан томилолт	2,280,000.00	6,000,000.00	3,802,000.0	-2,198,000.0	63.4
2.2.16	Зар сурталчилгаа, сургалт	4,169,454.54	6,000,000.00	2,882,590.9	-3,117,409.1	48.0
2.2.17	Бусад татвар даатгал	3,697,796.00	3,700,000.00	6,803,997.8	3,103,997.8	183.9
2.2.18	Гадны үйлчилгээний хөлс	25,594,800.00	25,000,000.00	29,185,700.0	4,185,700.0	116.7
2.2.19	Харуул хамгаалалт, программ үйлчилгээ	6,522,000.00	6,530,000.00	6,570,000.0	40,000.0	100.6
2.2.20	Шагнал урамшуулал тэтгэмж	28,160,150.00	30,000,000.00	28,511,290.2	-1,488,709.8	95.0
2.2.21	Найдваргүй авлагын зардал	5,417,042.89	5,500,000.00	6,066,160.8	566,160.8	110.3
2.2.22	Зээлийн хүү	-	0	0.0	0.0	0.0
2.2.23	Бусад	222,828,950.02	110,000,000.00	77,327,663.1	-32,672,336.9	70.3
	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,143,665,305.59	3,649,905,000.00	3,427,245,229.88	222,659,770.12	93.9
2.3	Үйл ажиллагааны бус зардал	-	0	-	0.00	0.0
3	Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-246,231,549.60	-552,498,300.00	-179,977,651.63	-372,520,648.37	32.6
4	Орлогын татвар	-	-	213,875.71	-213,875.71	0.0
5	Цэвэр ашиг алдагдал	-246,231,549.60	-552,498,300.00	-180,191,527.34	-372,306,772.66	32.6
6	Орлогын нэг төгрөгт ноогдох зардал	1.07	1.15	1.05	0.10	91.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,275,115.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс, 14,548,913.2 мянган төгрөгийн 3 алдаа залруулсан, 2,135.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн, 724,067.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аж ахуйн материалыг хөдөлмөр хамгааллын дансанд бүртгэж тайлагнасан	1	7,650.7					1	7,650.7				
Үнэ төлбөргүй авсан хөрөнгийг холбогдох стандартын дагуу бүртгэж тайлагнаагүй	1	12,724,338.1					1	12,724,338.1				
Нийслэлийн 100 хувь өмчит хөрөнгийг хувийн өмч дансанд бүртгэж тайлагнасан	1	1,816,924.4					1	1,816,924.4				
Дүн	3	14,548,913.2					3	14,548,913.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	2,135.0					1	2,135.0				
Дүн	1	2,135.0					1	2,135.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлбэл зохих 19 төрлийн 145 мэдээллээс 1 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	445,815.6					1	445,815.6
Дүн	1	445,815.6					1	445,815.6
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдагдалтай ажилласан боловч ажиллагсдад үр дүнгийн урамшуулал олгосон	1	50,245.8					1	50,245.8
Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хийгдээгүй	1	228,006.2					1	228,006.2
Дүн	2	278,252.0					2	278,252.0
Нийт дүн	3	724,067.6					3	724,067.6